



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/11/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Утас: 70522734	У.Оюунтүлхүүр
	Аудитын менежер:	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Утас: 70523020	
	Аудитор:	Б.Ариунбаатар
		Цахим хаяг: Ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин: .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4.Аудитын тайлан .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5.Аудитын илрүүлэлт .....	14
<b>5.1 Зөвлөмж.....</b>	<b>15</b>
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023.02.14 № 1-6/53

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Н.ГАНТОГТОХ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үндсэн хөрөнгө материаллаг хэмжээгээр нэмэгдсэн ба энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг ЗДТГ-ын хөрөнгөд бүртгүүлсэнтэй холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын дарга тайлант хугацаанд Овооны тахилгад 2 удаа тус бүр 20 л бензин зарцуулж, автомашин ашиглаж, нийт 108.8 мянган төгрөгийн 40л бензин зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

010000315

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>68,194,948.08</b>	<b>75,202,340.85</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,060,429.23	1,869,247.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	65,926.23	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	8,994,503.00	1,869,247.00
3351	Байгууллагаас авах авлага	8,994,503.00	1,869,247.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	59,134,518.85	73,333,093.85
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,100,530.62	6,100,530.62
35110	Тусгай зориулалттай материал	6,100,530.62	6,100,530.62
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,033,988.23	67,232,563.23
35410	Бичиг хэргийн материал	2,070,200.00	3,590,140.00
35420	Аж ахуйн материал	38,318,013.23	43,857,523.23
35430	Сэлбэг хэрэгсэл	6,573,900.00	7,405,900.00
35470	Бусад хангамжийн материал	6,071,875.00	12,379,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,866,743,535.87</b>	<b>1,930,110,783.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,866,743,535.87	1,930,110,783.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,791,847,327.51	1,856,060,241.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,321,520,802.00	1,510,486,394.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(108,377,819.09)	(153,812,621.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	362,867,500.00	362,867,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(265,597,541.80)	(288,396,958.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,699,520.30	138,086,620.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,364,521.73)	(88,488,068.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,182,998.20	103,182,998.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,231,410.60)	(66,664,300.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	862,230,071.00	862,230,071.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(472,082,270.77)	(523,431,393.13)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	74,896,208.36	74,050,541.72
39301	Програм хангамж	3,566,000.00	3,566,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,475,791.64)	(2,321,458.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	72,806,000.00	72,806,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,934,938,483.95</b>	<b>2,005,313,124.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>25,000.00</b>	<b>325,147.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	25,000.00	325,147.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	25,000.00	325,147.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	25,000.00	325,147.00
41361	Байгууллагад төлөх өглөг	25,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	325,147.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,934,913,483.95</b>	<b>2,004,987,977.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,934,913,483.95	2,004,987,977.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	942,714,114.56	942,714,114.56
51101	Өмч: - төрийн	942,714,114.56	942,714,114.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	449,270,008.91	519,344,502.30
51210	Өмнөх үеийн үр дүн	449,270,008.91	449,270,008.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	70,074,493.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	542,929,360.48	542,929,360.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,934,938,483.95</b>	<b>2,005,313,124.34</b>

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>695,351,354.19</b>	<b>590,514,004.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>318,047,875.20</b>	<b>193,369,475.00</b>

<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>318,047,875.20</b>	<b>193,369,475.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,573,600.00	1,437,413.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,573,600.00	1,437,413.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	299,030,139.20	188,965,592.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	17,444,136.00	2,966,470.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>377,303,478.99</b>	<b>397,144,529.01</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,156,931.00</b>	<b>14,417,535.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,540,000.00	3,091,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,616,931.00	11,326,535.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>357,146,547.99</b>	<b>382,726,994.01</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	357,146,547.99	382,726,994.01
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>494,954,718.83</b>	<b>520,439,510.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>494,954,718.83</b>	<b>520,439,510.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>493,754,718.83</b>	<b>519,639,510.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>199,207,132.11</b>	<b>204,946,731.75</b>
210101	Үндсэн цалин	199,207,132.11	167,513,072.75
210102	Нэмэгдэл	-	26,186,365.00
210104	Урамшуулал	-	11,247,294.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,989,249.82</b>	<b>25,098,432.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,909,332.65	17,789,659.16
210202	Тэтгэмжийн даатгал	1,975,259.69	2,099,867.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,734,463.10	1,639,573.87
210204	Ажилгүйдлийн даатгал	423,852.82	325,295.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,946,341.56	3,244,036.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,692,800.83</b>	<b>84,029,511.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,799,083.83	6,826,134.00
210302	Түлш, халаалт	62,733,100.00	75,602,780.00
210303	Цэвэр, бохир ус	2,160,617.00	1,600,597.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,756,382.00</b>	<b>35,797,828.00</b>
210401	Бичиг хэрэг	2,770,580.00	3,320,960.00
210402	Тээвэр, шатахуун	21,866,320.00	19,956,748.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,505,640.00	3,411,810.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,385,950.00	9,108,310.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,227,892.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,502,120.00</b>	<b>280,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,495,120.00	-
210502	Хоол, хүнс	7,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	280,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>468,100.00</b>	<b>300,000.00</b>
210604	Урсгал засвар	468,100.00	300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>716,000.00</b>	<b>6,955,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	716,000.00	6,955,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,697,175.00</b>	<b>18,246,563.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,784,956.00	17,115,418.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,025.00	364,275.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	466,722.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	179,194.00	179,148.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>134,725,759.07</b>	<b>143,985,444.38</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,500.00	-

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,697,259.07	138,985,444.38
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,200,000.00</b>	<b>800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,200,000.00</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	800,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>200,396,635.36</b>	<b>70,074,493.39</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>200,396,635.36</b>	<b>70,074,493.39</b>

**Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>398,577,451.99</b>	<b>407,576,445.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,573,600.00</b>	<b>1,437,413.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,573,600.00</b>	<b>1,437,413.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,573,600.00	1,437,413.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,573,600.00	1,437,413.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>397,003,851.99</b>	<b>406,139,032.01</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39,857,304.00</b>	<b>23,412,038.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,540,000.00	3,091,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,317,304.00	20,321,038.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>357,146,547.99</b>	<b>382,726,994.01</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	357,146,547.99	382,726,994.01
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>368,744,948.99</b>	<b>392,320,098.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>368,744,948.99</b>	<b>392,320,098.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>367,544,948.99</b>	<b>391,520,098.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>199,273,058.34</b>	<b>204,908,525.52</b>
210101	Үндсэн цалин	199,273,058.34	167,551,878.72
210102	Нэмэгдэл	-	26,173,803.00
210104	Урамшуулал	-	11,182,843.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,989,249.82</b>	<b>25,005,565.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,909,332.65	17,729,610.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,975,259.69	2,091,713.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,734,463.10	1,632,870.20
210204	Ажилгүйдлийн даатгал	423,852.82	323,642.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,946,341.56	3,227,727.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,660,800.83</b>	<b>84,029,511.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,799,083.83	6,826,134.00
210302	Түлш, халаалт	62,701,100.00	75,602,780.00
210303	Цэвэр, бохир ус	2,160,617.00	1,600,597.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,738,720.00</b>	<b>21,802,958.00</b>
210401	Бичиг хэрэг	2,439,300.00	4,150,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,527,080.00	12,250,748.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,505,640.00	3,381,810.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,900.00	2,020,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,503,570.00</b>	<b>620,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,303,570.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	620,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,495,000.00</b>	<b>5,092,850.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	115,000.00	112,900.00
210602	Тавилга	2,000,000.00	-

210604	Урсгал засвар	1,380,000.00	4,979,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>716,000.00</b>	<b>6,955,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	716,000.00	6,955,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,768,250.00</b>	<b>38,105,688.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,856,031.00	36,974,543.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,025.00	364,275.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	466,722.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	179,194.00	179,148.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>400,300.00</b>	<b>5,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,300.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,200,000.00</b>	<b>800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,200,000.00</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	8,994,503.00	1,869,247.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,994,503.00	1,869,247.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>20,838,000.00</b>	<b>13,387,100.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>20,838,000.00</b>	<b>13,387,100.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,838,000.00</b>	<b>13,387,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>20,838,000.00</b>	<b>13,387,100.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,838,000.00	13,387,100.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(20,838,000.00)</b>	<b>(13,387,100.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>

**Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	248,838,373.55	1,734,481,848.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	248,838,373.55	1,734,481,848.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	200,396,635.36	200,396,635.36
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	449,235,008.91	1,934,878,483.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	449,235,008.91	1,934,878,483.95

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	449,235,008.91	1,934,878,483.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	70,074,493.39	70,074,493.39
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	519,309,502.30	2,004,952,977.34

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	395,281,000.00	384,164,407.01	11,116,592.99	97.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	395,281,000.00	384,164,407.01	11,116,592.99	97.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	394,481,000.00	383,364,407.01	11,116,592.99	97.2
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	208,192,200.00	204,908,525.52	3,283,674.48	98.4
210101	Үндсэн цалин	170,229,400.00	167,551,878.72	2,677,521.28	98.4
210102	Нэмэгдэл	26,590,000.00	26,173,803.00	416,197.00	98.4
210104	Урамшуулал	11,372,800.00	11,182,843.80	189,956.20	98.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,080,300.00	25,005,565.49	4,074,734.51	86.0
210201	Тэтгэврийн даатгал	19,774,600.00	17,729,610.76	2,044,989.24	89.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,326,400.00	2,091,713.98	234,686.02	89.9
210203	даатгал ҮОМШӨ-ний	1,861,100.00	1,632,870.20	228,229.80	87.7
210204	даатгал Ажилгүйдлийн	465,300.00	323,642.85	141,657.15	69.6
210205	даатгал Эрүүл мэндийн	4,652,900.00	3,227,727.70	1,425,172.30	69.4
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	87,533,700.00	84,029,511.00	3,504,189.00	96.0
210301	Гэрэл, цахилгаан	7,968,800.00	6,826,134.00	1,142,666.00	85.7
210302	Түлш, халаалт	77,753,100.00	75,602,780.00	2,150,320.00	97.2
210303	Цэвэр, бохир ус	1,811,800.00	1,600,597.00	211,203.00	88.3
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,076,500.00	21,076,310.00	190.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,382,000.00	3,381,810.00	190.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,480,000.00	18,479,950.00	50.00	100.0
210604	Урсгал засвар	4,980,000.00	4,979,950.00	50.00	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	6,770,300.00	6,755,000.00	15,300.00	99.8
210702	Дотоод албан томилолт	6,770,300.00	6,755,000.00	15,300.00	99.8
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,728,000.00	17,489,545.00	238,455.00	98.7

4417144353  
ЕНОА0056 9025707

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,400,000.00	16,358,400.00	41,600.00	99.7
210803	Даатгалын үйлчилгээ	395,500.00	364,275.00	31,225.00	92.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	561,500.00	466,722.00	94,778.00	83.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	191,000.00	121,000.00	70,000.00	63.4
210807	Газрын төлбөр	180,000.00	179,148.00	852.00	99.5
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	395,281,000.00	384,164,407.01	11,116,592.99	97.2
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	394,281,000.00	382,726,994.01	11,554,005.99	97.1
132001	Орон нутгийн төсвөөс	394,281,000.00	382,726,994.01	11,554,005.99	97.1
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	1,437,413.00	(437,413.00)	143.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,437,413.00	(437,413.00)	143.7

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>21,542,791.00</b>	<b>(21,542,791.00)</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>21,542,791.00</b>	<b>(21,542,791.00)</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	21,542,791.00	(21,542,791.00)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	726,648.00	(726,648.00)
210402	Тээвэр, шатахуун	-	726,648.00	(726,648.00)
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	200,000.00	(200,000.00)
210702	Дотоод албан томилолт	-	200,000.00	(200,000.00)
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	20,616,143.00	(20,616,143.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	20,616,143.00	(20,616,143.00)
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	23,412,038.00	(23,412,038.00)
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	23,412,038.00	(23,412,038.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,091,000.00	(3,091,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,321,038.00	(20,321,038.00)

4417144353  
ЕНОА0056 9025707

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх алба, байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа, сумын ИТХ-ын тогтоол, Сумын Засаг даргын захирамж, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр сумын нийгэм эдийн засгийн тухайн жилийн зорилтод хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажилладаг байна.

Эрхэм зорилго: Төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн ил тод хөнгөн шуурхай явуулахын зэрэгцээ нутаг дэвсгэрийн зохистой байршил, байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн давуу талд тулгуурлан сумаа нийгэм эдийн засгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэн ажиллах.

Алсын хараа: Ухаалаг төлөвлөлт, оновчтой гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болно.

2022 зорилт: Хүүхэд хөгжлийг дэмжих жил

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин:**

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70.4 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,060.4	1,869.2	7,191.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	59,134.5	73,333.1	(14,198.6)
Үндсэн хөрөнгө	1,866,743.5	1,930,110.8	(63,367.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,934,938.5</b>	<b>2,005,313.1</b>	<b>(70,374.6)</b>
Өр төлбөр	25.0	325.1	(300.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,934,913.5	2,004,988.0	(70,074.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,934,938.5</b>	<b>2,005,313.1</b>	<b>(70,374.6)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 1.9 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлсэн авлага бөгөөд тайлант онд 7.2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73.3 сая төгрөг болж өмнөх оноос 14.2 сая төгрөгөөр өссөн нь өвс, хивэг болон бусад аж ахуйн материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,930.1 сая төгрөг болж 63.4 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаснаас шалтгаалжээ.

Өр төлбөр 0.3 сая төгрөг болж өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь жилийн эцэст гүйлгээний программд гацалт үүссэнээс шалтгаалан шилжүүлэг хийгдээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,005.0 сая төгрөг болж 70.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 110.1 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 19.8 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 520.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 520.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24 хувиар бууруулж 395.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 395.3 сая төгрөгийг орон төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 384.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 384.2 сая төгрөг буюу 11.1 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.3 сая төгрөг, нийт 23.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: тээвэр шатахуун 0.7 сая төгрөг, дотоод албан томилот 0.2 сая төгрөг, бусдаар

гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээ 20.6 сая төгрөг, нийт 21.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус байгууллагад тайлант онд тусгайлсан төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4.Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Ариунбаатар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1,934.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 19.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,544.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 324.8 сая төгрөгийн 15 гүйлгээг бүрэн байршуулсан, зарлагын 74.0 сая төгрөгийн 5 ажил гүйлгээнээс 39.3 сая төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, өмч хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 15 тушаал шийдвэр гарснаас 4 тушаалыг байршуулаагүй, 6 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 8 горим сорил хэрэгжүүлж, аудитын явцад санхүүгийн тайланд 17.7 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 7.0 сая төгрөгийн 2 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлсэн. Үүнд, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдаагүй албан шаардлага, сахилгын шийтгэлтэй албан хаагчид урамшуулал олгосон төлбөрийн акт, журмын дагуу бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, нэмэлт санхүүжилтийн орлогыг буруу бүртгэсэн зөвлөмж байна. Эдгээр зөвлөмжийг хугацаандаа бүрэн хэрэгжүүлж, холбогдох нотлох баримтыг ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	857.7	1	857.7	100
Албан шаардлага	2	1,132.3	1	1,132.3	100
Зөвлөмж	2	5,028.0	2	5,028.0	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>7,018.0</b>	<b>5</b>	<b>7,018.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг дутуу тайлагнасан ба дараагийн аудитаар орлого, зарлагын зарцуулалтыг үзэх шаардлагатай.

#### 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8 алдаа, зөрчил илэрснээс, 5 алдааг залруулж, 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллагын дарга тайлант хугацаанд Овооны тахилгад 2 удаа тус бүр 20 л бензин зарцуулж, автомашин ашиглаж, нийт 108.8 мянган төгрөгийн 40л бензин зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

#### Үр дагавар:

Батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх

#### Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг мөрдөж, төсвийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулахгүй байх;

### 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 324.8 сая төгрөгийн 15 гүйлгээг бүрэн байршуулсан, зарлагын 74.0 сая төгрөгийн 5 ажил гүйлгээнээс 39.3 сая төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, өмч хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 15 тушаал шийдвэр гарснаас 4 тушаалыг байршуулаагүй, 6 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Үр дагавар:

Мэдээллийн ил тод байдал алдагдах, хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, өмнөх мэдээллийг нөхөн байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье.

## 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа албан хаагчаас тэтгэврийн даатгал суутгасныг авлагаар өглөгөөр тусгасан.	1	65.1			1	65.1	1	65.1				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй	1	12,966.8	1	12,966.8			1	12,966.8				
Авлага бүртгээгүй орхигдуулсан	1	2,113.2	1	2,113.2			1	2,113.2				
Хөрөнгө давхардуулан бүртгэсэн	1	2,520.0			1	2,520.0	1	2,520.0				
Нэмэлт орлогыг давхардуулан бүртгэсэн	1	1,437.4			1	1,437.4	1	1,437.4				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>19,102.5</b>	<b>2</b>	<b>15,080.0</b>	<b>3</b>	<b>4,022.6</b>	<b>5</b>	<b>19,102.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	108.8	-	-	-	-	1	108.8	-	-
Тайлант хугацааны авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	661.4			1	661.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>770.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>661.4</b>	<b>1</b>	<b>108.8</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн байршуулаагүй	1	-	-	-	-	-	-	1	-	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
-	-	-	-	-	-	-	-	-	-	
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	